БМҮ ЗӨВЛӨЛ

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 09 өдөр Дугаар 28 Улаанбаатар хот

Заавар, тангараг батлах тухай

"Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм"-ийн 1 дүгээр зүйлийн 1.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.5-ын "д" заалт, "Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь

Нэг. "Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн лого, тэмдэг, бүртгэлийн дугаар ашиглах заавар"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн шинжээчдийн тангараг"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны ажилтан албан хаагчдад, шинжээчийн тангарагийг мөрдлөг болгон ажиллахыг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн шинжээчдэд тус тус үүрэг болгосугай.

Хавсралт хуудас

ДЭД ДАРГА,
АЖЛЫН АЛБАНЫ ЗАХИРАЛ О. Янжмаа О.ЯНЖМАА

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албаны захирлын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 26 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЛОГО, ТЭМДЭГ, БҮРТГЭЛИЙН ДУГААР АШИГЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь өөрийн билэгдэл бүхий лого болон сургууль хөтөлбөрийг магадлан итгэмжилснийг гэрчлэх тэмдэгтэй байна.

1.2. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэгдсэн сургууль, сургалтын хөтөлбөр нь лого, тэмдэгийг ашиглах эрхтэй.

1.3. Магадлан итгэмжлэгдээгүй болон магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа нь дууссан сургууль, хөтөлбөр Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн лого болон тэмдэгийг хэрэглэхийг хориглоно.

Хоёр. Магадлан итгэмжлэгдсэн тэмдэг ашиглах заавар

2.1. Магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр нь тус хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэнээс хойш төгсч буй төгсөгчдийн диплом дээр лого бүхий дүрстэй "Магадлан итгэмжлэгдсэн" гэсэн бичигтэй тэмдэгийг дарж хэрэглэнэ.

2.2. Магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж тухайн жилд төгсөх төгсөгчдийн тоо болон дипломын загварыг диплом хэвлэгдэхээс 3 сараас доошгүй хугацааны өмнө Ажлын албанд мэдэгдэнэ.

2.3. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл тухайн жилд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр суралцан төгсөж буй төгсөгчдийн тоо болон холбогдох бусад мэдээллийг Үндэсний үнэт цаас ХК болон эрх бүхий хэвлэлийн байгууллагад хүргүүлж дипломын үнэт цаасан дээр нууцлал бүхий тэмдгийг хэвлүүлнэ.

2.4. Дипломын загвараас хамааран хөндлөн болон босоо хэлбэрийн тэмдэгнээс сонгон хэрэглэж болно. Тэмдэгийг дипломонд хэвлэхдээ дипломын баруун дээд талд сургуулийн логоны харалдаа байрлуулж хэвлэнэ.

2.5. Веб сайтад байршуулахдаа батлагдсан өнгө хэмжээг өөрчлөхгүйгээр веб сайтын үндсэн нүүрэнд байршуулна. Англи хэл дээрх веб сайтад англи тэмдэгийг байршуулж болно.

Гурав. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн лого, бүртгэлийн дугаар ашиглах заавар

3.1. Магадлан итгэмжлэгдсэн сургууль хөтөлбөр нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн логог /цаашид лого гэх/ өөрийн веб сайт, зурагт хуудас, тогтмол эрхлэн гаргадаг сэтгүүл, танилцуулганд байршуулж болно.

3.2. Сургууль, хөтөлбөрийн танилцуулга, зурагт хуудас, тогтмол хэвлэгддэг сэтгүүл, гарын авлагад логог байршуулж болно. Логог хэвлэмэл материалд байршуулахдаа сургуулийн логотой ижил хэмжээгээр, өнгө хэлбэрийг алдагдуулахгүйгээр харалдаа хэвлэсэн байна.

3.3. Лого болон тэмдэгийн өнгө дүрсийг солих, хэмжээг алдагдуулах зэргээр ашиглахыг хориглоно.

3.4. Бүртгэлийн дугаарыг магадлан итгэмжлэгдсэн сургууль, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн гэрчилгээний зүүн доод буланд байршуулна.

3.5. Магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага 01, сургалтын хөтөлбөр 02, урьдчилсан магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр 03-аар эхэлсэн 5 орон бүхий бүртгэлийн дугаартай байна.

-o0o-

МОНГОЛ УЛС
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
БАКАЛАВРЫН ДИПЛОМ

№ D201826139

Монгол услын иргэн Гангаагийн ОТГОНБААТАР *нь*
2018 онд Шинжлэх ухааны сургуульд
УЛС ТӨР СУДЛАЛ
мэргэжил (D312200)-ээр суралцан төгссөн тул төгсөлтийн комиссын
2018 оны 06 дугаар сарын 11-ний шийдвэрийг үндэслэн,
Захирлын 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/195 тоот тушаалаар
Улс төр судлалын БАКАЛАВР *зэрэг олгов.*

Удирдах зөвлөлийн дарга	*Захирал*	*Төгсөлтийн комиссын дарга*	*Шинжлэх ухааны сургуулийн захирал*

Улаанбаатар хот *2018 оны 06 дугаар сарын 18* *Бүртгэлийн дугаар 30061*

МОНГОЛ УЛС
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

БАКАЛАВРЫН ДИПЛОМ

Монгол услын иргэн Гангаагийн ОТГОНБААТАР *нь*
2018 онд Шинжлэх ухааны сургуульд
УЛС ТӨР СУДЛАЛ
мэргэжил (D312200)-ээр суралцан төгссөн тул
төгсөлтийн комиссын
2018 оны 06 дугаар сарын 11-ний шийдвэрийг үндэслэн,
Захирлын 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/195
тоот тушаалаар
Улс төр судлалын БАКАЛАВР *зэрэг олгов.*

Удирдах зөвлөлийн дарга

Захирал

Төгсөлтийн комиссын дарга

Шинжлэх ухааны сургуулийн захирал

2018 оны 06 дугаар сарын 18

Бүртгэлийн дугаар 30061

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албаны захирлын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 25 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

БМҮ
ЗӨВЛӨЛ

ШИНЖЭЭЧИЙН ТАНГАРАГ

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн шинжээч БИ үл алагчлах зарчмыг баримтлан, магадлан итгэмжлэх үйл ажиллагааны дүрэм журмыг мөрдөн ажиллаж, сургууль хөтөлбөрийн баримт бичиг, мэдээллийг ашиглахдаа нууцлалыг чандлан хадгалахаа батлан **ТАНГАРАГЛАЖ** байна.

ТАНГАРАГЛАЖ байна
ТАНГАРАГЛАЖ байна